



**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/02

Замын-Үүд сум

Тариф шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Манай үйлдвэрийн газарт өргөн, нарийн царигаар нийлүүлэгдэх газрын тосны бүтээгдэхүүний нэг сард хадгалах савны хөлсийг 2000 м³ багтаамжтай нэг сав 36,000,000.0 (гучин зургаан сая) төгрөг, 3000 м³ багтаамжтай нэг сав 54,000,000.0 (тавин дөрвөн сая) төгрөг, 5000 м³ багтаамжтай нэг сав 90,000,000.0 (ерэн сая) төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Нарийн царигаар нийлүүлэгдэх газрын тосны бүтээгдэхүүний хадгалах хөлсийг нэг хоногт тонн тутамд 770 (долоон зуун дал) төгрөгөөр тогтоосугай.

3. Өргөн, нарийн царигаар нийлүүлэгдэх газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачилтын хөлсийг 18,000.0 (арван найман мянга) төгрөгөөр тогтоосугай.

4. Энэхүү тушаалыг шинэчлэн баталж байгаатай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/51 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

5. Тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хяналт тавьж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай)-д даалгасугай.

ЗАХИРАЛ  ГАНСҮХ

